

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2019 оны 4 дүгээр сарын 24-ний өдөр

№ ..19/24

Улаанбаатар хот

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга сонгох тухай

Компанийн тухай Монгол Улсын хуулийн 78 дугаар зүйлийн 78.1 дэх хэсэг, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 10.1 дэх хэсэг, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн үйл ажиллагааны журмын 7.1 болон 8.1 дэх хэсэг, санал хураалтын дүн, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2019 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн даргаар Очирсүрэнгийн Болдбаатарыг сонгосугай.
2. Компанийн тухай, Үнэт цаасны зах зээлийн тухай, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль тогтоомж, Компанийн дүрэм, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Үйл ажиллагааны журам, холбогдох бусад баримт бичгийг мөрдөж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга (О.Болдбаатар)-д үүрэг болгосугай.
3. ТУЗ-ийн дарга сонгогдсонтой холбоотойгоор Санхүүгийн Зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж болон олон нийтэд зохих журмын дагуу мэдээлэхийг “ЛэндМН ББСБ” ХК-ийн Гүйцэтгэж захирал (Б.Гантулга)-д үүрэг болгосугай.



..... /О.БОЛДБААТАР/

..... /Ч.НОМИН/

..... /МЭТЬЮ ВЭЛЧ/

..... /Б.ДЭЛГЭРЖАРГАЛ/

..... /В.БАЯРСАЙХАН/

..... /Ж.ЖАРГАЛСҮРЭН/

..... /С.БОРГИЛ/

..... /Н.ЦЭВЭГМИД/

..... /С.ЭНХ-АМГАЛАН/

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2019 оны 4 дүгээр сарын 24-ний өдөр


№ 19/25

Улаанбаатар хот

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нарийн бичгийн дарга томилох тухай

Компанийн тухай Монгол Улсын хуулийн 82 дугаар зүйлийн 82.1 дэх хэсэг, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 13.1 дэх хэсэг, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн үйл ажиллагааны журмын 8.1 дэх хэсэг, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн даргын санал, ТУЗ-ийн 2019 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нарийн бичгийн даргаар Жаргалсайханы Мөнхцэцэгийг томилсугай.
2. Компанийн тухай, Үнэт цаасны зах зээлийн тухай, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль тогтоомж, Компанийн дүрэм, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Үйл ажиллагааны журам, холбогдох бусад баримт бичгийг мөрдөж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нарийн бичгийн дарга (Ж.Мөнхцэцэг)-д үүрэг болгосугай.
3. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга шинээр томилогдсонтой холбоотойгоор Компанийн болон Хөрөнгийн биржийн цахим хуудаст байршсан мэдээлэлд өөрчлөлт оруулах, Санхүүгийн Зохицуулах хороо болон олон нийтэд мэдээлэх, ТУЗ-ийн нарийн бичгийн даргатай хөдөлмөрийн гэрээ байгуулахыг Гүйцэтгэх захирал (Б.Гантулга)-д үүрэг болгосугай.



“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2019 оны 4 дүгээр сарын 24-ний өдөр

№ 19/26

Улаанбаатар хот

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хороодын бүрэлдэхүүнийг батлах тухай

Компанийн тухай Монгол Улсын хуулийн 81 дүгээр зүйл, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 9.1, 14 дүгээр зүйл, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн үйл ажиллагааны журмын 4.1 дэх хэсэг, хороодын хурлаас гарсан шийдвэрийг тус тус үндэслэн Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хороодын бүрэлдэхүүнийг дор дурдсанаар баталсугай. Үүнд:

а. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Эрсдлийн удирдлагын хороо:

Хорооны дарга: Б.Дэлгэржаргал;

Гишүүд: В.Баярсайхан;
Мэтью Вэлч Нэвил;
Н.Цэвэгмид;
Ч.Номин.

б. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Аудитын хороо:

Хорооны дарга: Ж.Жаргалсүрэн;

Гишүүд: О.Болдбаатар;
С.Боргил.

в. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин, урамшууллын хороо:

Хорооны дарга: О.Болдбаатар;

Гишүүд: С.Боргил;
Ч.Номин.

2. Компанийн тухай, Үнэт цаасны зах зээлийн тухай, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль тогтоомж, Компанийн дүрэм, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Үйл ажиллагааны журам, холбогдох бусад баримт бичгийг мөрдөж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хороодын дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

3. ТУЗ-ийн хороодын бүрэлдэхүүн шинэчлэгдсэнтэй холбоотойгоор Компанийн болон Хөрөнгийн биржийн цахим хуудаст байршсан мэдээлэлд өөрчлөлт оруулах, Санхүүгийн Зохицуулах хороо болон олон нийтэд мэдээлэхийг Гүйцэтгэх захирал (Б.Гантулга)-д үүрэг болгосугай.

